



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 12 сарын 07 өдөр

Дугаар А/767

Ховд

Хөрөнгө гаргах тухай


Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 14.2.12, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 11/02 тогтоол, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын 2020 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн ХЭГ/2013 албан бичгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улаанбаатар хотод нийтийн тээврийн хэрэгслийн цахим картаар үнэ төлбөргүй зорчсон аймгийн харъяа ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нөхөн олговорт 36000.0 мянган төгрөг /гучин зургаан сая/-ийг үйлчилгээний байгууллагуудын нэхэмжлэл, халамжийн байгууллагуудаас ирүүлсэн нэрсийн жагсаалтыг үндэслэн зарцуулсугай.

2. Нөхөн олговорт зарцуулах 36000.0 мянган төгрөгийг аймгийн Засаг дарга дансанд 2020 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний жагсаалтаас зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/ нарт зөвшөөрсүгэй.

ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ



02.3517  
D/Zax-A/767-Bo